



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 721

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Засгийн газар, Олон улсын ассоциаци хооронд байгуулсан 2019 оны “Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл”-ийн нэмэлт санхүүжилт, Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж бий болсон, нийт 1,160,215,184.00 (нэг тэрбум нэг зуун жаран сая хоёр зуун арван таван мянга нэг зуун наян дөрвөн) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн “Б” блокийн барилгад хийсэн их засварын хөрөнгийг хавсралтад заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал В.Баярмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг хүлээн авсан акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007332
35-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 12 дугаар сарын 22 ны/ний өдрийн
 721 дугаар тогтоолын хавсралт

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 КАПИТАЛЖУУЛАН БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж (метр, кв)	Тоо хэмжээ	Балансад бүртгэх үнэ (төгрөг)
1	Ханын дулаалгын ажил	2023.10.01	м/кв	3359.8	646,130,974.00
2	Хаалга, цонхны ажил	2023.10.01	м/кв	621.2	438,730,082.00
3	Дээврийн дулаалгын ажил	2023.10.01	м/кв	245	51,664,895.00
4	агааржуулалтын хоолойн засварын ажил	2023.10.01	м	350	23,689,233.00
НИЙТ ДҮН					1,160,215,184.00
					(нэг тэрбум нэг зуун жаран сая хоёр зуун арван таван мянга нэг зуун наян дөрвөн)